


Удирдах зөвлөлийн
2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн
24/07 тоот тогтоолын хавсралт 02



ХУРАЛДААНЫГ БАЙРЛАХ БАЙРНААС БУСАД ГАЗАРТ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. “Хуралдааныг байрлах байрнаас бусад газарт хийх нийтлэг журам” (цаашид “журам” гэх)-аар Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын болон допингийн Давж заалдах комиссын ажиллагааг иргэдэд ойртуулах, оролцогчдын эрхийг хангах зорилгоор арбитр болон комиссын байрлаж байгаа байрнаас бусад газарт хуралдааныг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Энэ журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, Дэлхийн допингийн эсрэг дүрэм, олон улсын стандартууд, Допингийн эсрэг үндэсний дүрэм, Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомж, байрлах байрны нийтлэг шаардлага, стандарт, хуралдааны дэгийг сахиулах, даргалагч, хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангахтай холбоотой дүрэм, журмыг баримтална.

Хоёр. Хуралдааныг хийх газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх

- 2.1. Хуралдааныг тухайн байрлаж буй байранд хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд өөр байранд, эсхүл байрлах байрнаас бусад газарт хийх эсэхийг Бүрэлдэхүүн, Бүрэлдэхүүн даргалагч шийдвэрлэнэ.
- 2.2. Хуралдааныг өөр байранд хийх тохиолдолд энэ журмын зорилгыг илүү хангасан байдлыг харгалзана.
- 2.3. Хуралдааныг өөр байранд, эсхүл байрлах байрнаас бусад газарт хийх тохиолдолд хуралдаан хийх шаардлага хангасан байр, танхимаар хангах асуудлыг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын Ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх) хариуцна.
- 2.4. Хуралдааныг байрлах байрнаас бусад газарт хийх тохиолдолд Ажлын алба зохион байгуулна.

Гурав. Хуралдааныг байрлах байрнаас бусад газарт хийхэд бүрдүүлэх орчин, нөхцөл

- 3.1. Ажлын алба нь хуралдаан хийх танхим, түүний аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдал, хуралдааныг зохион байгуулах шаардлагатай орчинг бүрдүүлнэ.
- 3.2. Ажлын алба хуралдаан хийх байр, танхимд доор дурдсан нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 3.2.1. Хуралдаан хийх танхим нь хуралдааны оролцогчдын эрх, үүргийг хэрэгжүүлэхүйц орчин, нөхцөлтэй байх;
 - 3.2.2. Хуралдааны танхимд байвал зохих техник, тоног төхөөрөмжөөр хангагдсан байх;
 - 3.2.3. Хуралдаан хийх танхимд хаяг байрлуулсан байх;

- 3.2.4. Бүрэлдэхүүн, нарийн бичгийн дарга, хэргийн оролцогчид, өмгөөлөгч, ажил үүрэг гүйцэтгэх өрөө, хэргийн оролцогчийг байрлуулах, шаардлагатай тохиолдолд нотлох баримт, хэргийн материал хадгалах зэрэг хэсэгтэй байх;
- 3.2.5. Хуралдааныг ажиглах, сурвалжлах, олон нийтэд мэдээллийг хүргэх боломжтой байх;
- 3.2.6. Хуралдаан хийх танхим нь уг байранд байрлаж буй бусад байгууллага, ажилтнаас хуралдааны үйл ажиллагаанд аливаа байдлаар саад болохгүй байхаар зохицуулалт хийгдсэн байх;
- 3.2.7. Бусад

Дөрөв. Бусад

- 4.1. Хуралдааныг байрлах байрнаас бусад газарт хийхэд Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг баримтална.
- 4.2. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.